

## Мөнхийн Эзэний үг ч хугацаатай

*Та бүхнээс Библийн талаарх асуулт ирвэл бид баярлаад хариу өгөхийг хичээх болно!  
Мөнх гэсэн үгтэй холбоотой асуулт ирлээ.*



**АСУУЛТ:** "Их Эзэн минь үүрд мөнх оршигч, бас өвс ургамал хагдарсан ч Түүний үг үүрд орших болно. Хэрэв “үүрд” ба “мөнх” гэдэг үг еврейгээр “хэзээ ч дуусашгүй, эцэс төгсгөлгүй” гэсэн утгыг агуулаагүй юм бол Их Эзэний үг алга болно гэж үү?”

**ХАРИУ:** Энэ асуулт Исаиа 40:8-г дурдсан байна.  
Тухайлбал:

**"Өвс хатдаг, цэцэг ганддаг. Бидний Бурханы үг мөнхөд [еврей: улаам-д] тогтоно". (АБ2019).**



Исаиагийн энэ үгийг Петр грекээр иш татан бичсэн.

Үүнд:

**"Өвс хатдаг, цэцэг ганддаг. Өнө мөнхөд [грек: эон үед] гагцхүү Эзэний үг л оршино гэжээ. Энэ бол та нарт тунхаглагдсан сайнмэдээний үг мөн"** гэж бичив (1 Петр 1:24-25).



Исаиа, Петр хоёр хоёулаа Их Эзэний үгийг МӨНХӨД тогтож оршино гэж бичихдээ ямар ч төгсгөлгүй мөнхийг хэлээгүй, харин төгсгөл нь хараанаас далд буй ирээдүйн эон үед ортол тогтоно гэсэн. Энэ юу гэсэн үг вэ?

Их Эзэний үг биелэх учиртай

Юуны өмнө "тогтох" гэж орчуулсан еврей үйл үгийг авч үзье. Тэр үг "бат зогсох", "батлагдсан байх", "хүчинтэй байх", "орших", "хэрэгжих", "биелэх" гэсэн утгатай.

Жишээ нь, Исаиа 46:10: "Зорилго минь биелнэ. Хүссэн бүхнээ Би хэрэгжүүлнэ" гэж Их Эзэн хэлсэн (СМО).



Ертөнцийн Эзэн цагийн уртад олон янзын үгийг хэлсэн. Жишээлбэл, Нуахын үед газар дэлхий хүчирхийллээр дүүрсэн байсан учраас Их Эзэн үер буулгаж дэлхийг сөнөөх гэж байгаагаа Нуахад хэлж усан онгоц барихыг түүнд тушаасан (Эхлэл 6).

Үнэхээр усан галав болсны дараа шинэ эон үе эхлэхэд Их Эзэн Нуахтай "зоний үеийн турш амьдрах үеүдэд" зориулсан гэрээ хийж "махбодтой



бүхнийг дахин үерийн усаар устгахгүй. Газар дэлхийг сүйрүүлэх үер дахиж болохгүй" гэж ам тангаргаа өгчээ (Эхлэл 9:11-12; СМО).

Ертөнцийн Эзэний Нуахад хэлсэн бүх үг өнөөдөр ч Библид хадгалаастай бөгөөд хэзээ ч мартагдахгүй. Энэ утгаар Түүний үг үргэлж орших болно.

Гэтэл үер буулгана гэсэн Их Эзэний Нуахад хэлсэн эхний үг хэрэгжсэн учраас өнөөдөр хүчингүй болжээ. Өнөөдөр бид Их Эзэний Нуахад хэлсэн Үгийг өөртөө наалдуулж усан онгоц барих хэрэггүй. Их Эзэний Нуахад хэлсэн



тэр үг өнгөрсөн. Дахиад хамаг дэлхийг автсан үер болохгүйг Тэр Өөрөө амласан бөгөөд энэ үг нь дэлхий дээр хүн төрөлхтөний үеийнхэн амьдрах бүх үеүдийн турш тогтоно.

Ертөнцийн Эзэний Хууль өнгөрөх болно  
Есүсийн хэлсэн нэг үгийг анхааралтай уншаарай:

**"Тэнгэр газар өнгөрөн одож, БҮГД  
БИЕЛЭГДЭХ ХҮРТЭЛ Хуулиас ганц үсэг,  
ганц ч зураас өнгөрөн одохгүй" (Матай  
5:18).**

“Хууль” гэдэг нь Мосегийн бичсэн таван номыг хэлэх нь олонтаа. Есүсийн хэлснээс дүгнэхэд Мосегийн бичсэн бүх үг заавал биелэгдэх ёстой. Гэтэл биелснийхээ дараа тэнгэр, газрын хамт “өнгөрөн одох” болно. Өөрөөр хэлбэл, тэр үед “хугацаа нь дуусах” болно.

Тэнгэр газар хэзээ өнгөрөн одох вэ? Библийн сүүлчийн хэдэн бүлгийг харвал, айсуй ирэх мянган жилт хаант улсын дараа “анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одох” болно (Илчлэл 20:5,11-12; 21:1<sup>1</sup>).

Есүсийн үгнээс дүгнэхэд шинэ газар, шинэ тэнгэрт Мосегийн хууль үгүй байх болно. Тийм

---

1 Матай 5:18-д ба Илчлэл 21:1-т “өнгөрөн одох” гэж орчуулсан үг грекээр адилхан үг болох нь адилхан тохиолдолын тухай ярьж байгааг батална.



учраас Мосегийн хуулийг сахихаар зайлшгүй шаардлагатай сүмийн өргөө шинэ газар дээр байхгүй (Илчлэл 21:22).

Ертөнцийн Эзэний тодорхой зарим үг (эсвэл тэр үгийн үр дүн) үүрд оршихгүй буюу мөнхөд хүчинтэй байдаггүй, харин "хугацаатай" болохыг энэ ишлэлээс ч гэсэн ойлгогдоно.

### Исаиа Израйльд өгсөн амлалтыг ярьсан

Тийм байхад Исаиа, Петр хоёрын хэлснийг зөв ойлгохын тулд Их Эзэний ямар үг тогтоно гэснийг нь бид судлах хэрэгтэй. Хам сэдвийг нь үзвэл Исаиа Их Эзэний Израйльд өгсөн амлалтыг ярьсан байна. "Миний ард түмэн" буюу Израйль Синай уулын бэлд гэрээ тогтоосон ч тэр гэрээгээ зөрчиж шийтгүүлэх болсоныг Исаиа хальт дурдана (40:1-2). Хүмүүс өвс цэцэг шиг мөхөс дорой учраас үгэндээ хүрч чадалгүй үхдэг (6-7-р иш). Харин Их Эзэний Үг тэдний үнэнч бусаас болж хүчин төгөлдөрөө алдаагүй, энэ эоний эцэс ба дараагийн эонд ч биелэх өдрөө хүртэл хүчинтэй хэвээр тогтоно хэмээн Исаиа баталжээ.

Энэ бол Мосегийн хэлсэн нэг үгийн дагуу. Үүнд:

**"Зөв шударгаасаа, эсвэл сэтгэл цэгц шулуунаасаа болж та нар тэр газар нутгийг эзэмшихээр орж байгаа юм биш.**



**Харин... та нарын өвөг дээдэс Аврахаам, Ицхаак, Иаков нарт андгайлсан үгэндээ хүрэхийн тулд Бурхан ИАВЭ чинь та нарын өмнөөс тэднийг хөөн зайлуулах гэж байна." (Дэд хууль 9:5, СМО).**

“Үгэндээ хүрэх” гэсэн хэллэгт “тогтох” гэж дээр орчуулсан адилхан еврей үг орсон. Их Эзэн нэг ёсондоо “андгайлсан үгээ тогтоход хүргэх” буюу биелүүлэх тал дээр санаа тавьдгаа хэлсэн. Их Эзэний Үг замхрахгүй, биелтлээ орших шалтгаан нь Их Эзэн Өөрөө үгээ санаж тогтсон цагт нь биелүүлдэгт оршино.

Энэ зоний эцэст тэгвэл юу болох ёстой вэ?

**“Эзэн ИАВЭ сүр  
хүчээр ирж  
Эрх мэдлээрээ Өөрөө  
засаглана...  
Сүргээ хоньчин мэт  
хариулж, хургаа  
Өөрийн мутраар  
цуглуулна.  
Энгэртээ тэднийгээ  
тэвэрнэ.  
Эхийг нь ялгуухнаар  
дагуулна”  
(40:10-11; СМО).<sup>2</sup>**



2 100-р дуулал зэргээс харахад ИАВЭгийн хонин сүрэг бол Түүний сонгосон ард түмэн Израйль.



Есүс эргэн ирж Хаан болон Израйльд амласан Хаант улсыг байгуулна. Тэр үед "ИАВЭгийн суу алдар илчлэгдэж махбодот бүхэн үүнийг хамтдаа үзнэ" (5-р иш). Израйлийн сайхан ирээдүйн тухай Түүний үг биелэгдэх болно. Энэ сайхан мэдээг иудейчүүдэд түгээж (9-р иш), "эцгүүдэд өгсөн амлалтуудыг батлахын тулд" Есүс анх удаагаа ирсэн билээ (Ром 15:8).



Петр ч Исаиагийн сайн мэдээг зарласан  
Их Эзэний аль Үг эоний турш орших гэдгийг Петр өөрөө тодорхойлж өгсөн байна. Үүнд: "ЭОНИЙ ТУРШ гагцхүү Эзэний үг л оршино гэжээ. Энэ бол **та нарт** тунхаглагдсан **сайн мэдээний үг мөн**" гэж бичсэн (1 Петр 1:25). Хозлуулагсдын апостол Петр захидлаа газар сайгүй тархсан израйльчуудад хандан бичжээ (Галат 2:7; 1 Петр 1:1). Түүний энд ярьсан сайн мэдээ Исаиагийн ярьсан сайн мэдээтэй адилхан юм. Өөрөөр хэлбэл, Израйльд амласан Хаант улсын тухай



тэр сайн мэдээ юм. Энэ нь дээр хэлсэнчлэн энэ зоний эцэст биеллээ олох болно. Ертөнцийн Эзэний энэ талаарх үг зоний үеийн тогтсон цагт биелтэл хүчинтэй хэвээр гэдгийг Петр уншигчиддаа, эдний дотроос өнөөдөр танд санууллаа.

Өнөөдөр итгэгч израильчууд бидэнтэй адил Их Эзэний амлалтыг хүлээсээр байна. Тэд өнөөгийн хэцүү байдлаа хараад: “Зам минь ИАВЭгаас нууцлагдсан. Журамт явдлыг минь миний Бурхан үл тоосон” гэж бодож магадгүй. Гэтэл ингэж ярих хэрэггүйг Их Эзэн тэдэнд сануулдаг. Учир нь, “Ертөнцийн хязгаарыг бүтээгч” ИАВЭ бол “өнө мөнхийн Бурхан”. Юу гэвэл, Тэр бол эон үеүдийн турш оршин байдаг бөгөөд “эцэшгүй бас цуцашгүй. Түүний ухаанд хэн ч нэвтэршгүй. Цуцаж яадарсанд нь хүчийг өгнө. Чадал барагсанд нь тэнхээ нэмнэ” (27-29-р иш).

Эон үеүдийг бүхлээр нь Тэр удирддаг нь баталгаатай учраас Үгээ биелүүлтлээ хүчинтэй байлгах болно. Тэр үгийн биеллийг хартлаа хүлээх хүч чадлыг ч Мөнхийн Эзэн Өөрийн хүмүүстээ өгнө.

**Иймд бид “Түүнийг хараагүй боловч Түүнийг хайрладаг. Эдүгээ та нар Түүнийг харахгүй байгаа ч Түүнд итгэдэг.**



**Та нар хэлэхийн аргагүй, алдраар дүүрэн баяр хөөрөөр ихэд баярладаг.” (1 Петр 1:8)**

Хүн бид мөхөс дорой хэвээрээ байсан ч гэсэн Ертөнцийн их Эзэн Өөрийнхөө бүх амлалтаа цаг нь ирэхээр биелүүлэх нь гарцаагүй. Хэлсэн үгэндээ хүрэх нь Түүний нэр төр учраас тэр. Энэ бол бидний итгэл ба баяр хөөр билээ.





Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). [www.blueletterbible.org](http://www.blueletterbible.org)